БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2026/009/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Назгүл<br>Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .................... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .................... 5
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .................... 12
**3.1 Төлбөрийн акт** .................... 12
**3.2 Албан шаардлага** .................... 12
**3.3 Зөвлөмж** .................... 12
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .................... 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ТТӨХ | Тоног төхөөрөмж |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2026.02.24 № 132
танай ______ -ны № ______ -т

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.БАРШАГУЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2025 онд 1,681.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 983.9 сая төгрөг зарцуулж, 58.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832605000304

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,214,361.00** | **13,892,211.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 8,455,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 8,455,000.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 8,455,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 8,455,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 810,150.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 810,150.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 810,150.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 2,404,211.00 | 5,437,211.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,404,211.00 | 5,437,211.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 570,000.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 1,814,211.00 | 1,807,211.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 3,630,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 20,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,259,717.26** | **60,034,511.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 64,259,717.26 | 60,034,511.20 |
| **392** | **Биет хөрөнгө** | 63,310,891.30 | 59,371,177.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,837,203.28 | 3,837,203.28 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,534,881.60) | (1,790,695.20) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 62,280,200.00 | 62,280,200.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (28,165,058.27) | (59,305,158.23) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,691,350.00 | 62,730,350.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (19,693,031.53) | (25,342,923.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,166,625.00 | 35,518,905.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,271,515.58) | (18,556,703.57) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 948,825.96 | 663,333.34 |
| 39301 | Програм хангамж | 1,423,239.00 | 2,813,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (474,413.04) | (2,149,905.66) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **67,474,078.26** | **73,926,722.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **10,733,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 10,733,500.00 |
| **413** | **Өглөг** | - | 10,733,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 10,733,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 4,868,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 5,865,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **67,474,078.26** | **63,193,222.20** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 67,474,078.26 | 63,193,222.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 158,734,618.96 | 158,734,618.96 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (143,106,429.10) | (147,387,285.16) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (143,106,429.10) | (143,106,429.10) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (4,280,856.06) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 51,845,888.40 | 51,845,888.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **67,474,078.26** | **73,926,722.20** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,341,892,195.19** | **1,047,153,724.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **35,925,150.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 35,925,150.00 |
| 120017 | үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | | 34,975,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 950,150.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 950,150.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,341,892,195.19** | **1,011,228,574.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 248,000,000.00 | 13,000,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 7,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 240,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,093,892,195.19 | 998,228,574.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 998,228,574.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 1,093,892,195.19 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,343,242,900.00** | **1,051,335,260.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,343,242,900.00** | **1,051,335,260.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,261,570,781.19 | 1,036,056,620.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 474,707,925.19 | 520,183,420.23 |
| 210101 | Үндсэн цалин | 258,529,504.79 | 330,347,902.00 |
| 210102 | Нэмэгдэл | 185,113,013.93 | 142,809,911.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,728,644.61 | 18,210,072.00 |
| 210104 | Урамшуулал | 20,336,761.86 | 28,815,535.23 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,069,500.00 | 69,802,695.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,167,200.00 | 48,975,889.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,725,600.00 | 5,289,616.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,362,800.00 | 2,721,881.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,362,800.00 | 2,576,082.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,451,100.00 | 10,239,227.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,138,298.00 | 32,298,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,015,550.00 | 4,490,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,339,460.00 | 22,082,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,783,288.00 | 5,726,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,020,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,020,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,521,020.00 | 11,956,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,521,020.00 | 640,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 11,316,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17,927,350.00 | 16,591,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,927,350.00 | 16,591,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,359,740.00 | 3,437,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,767,340.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,471,500.00 | 1,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 127,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,300.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,600.00 | 2,110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 655,826,948.00 | 381,786,055.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 595,650,248.00 | 329,660,569.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,176,700.00 | 7,354,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 44,770,886.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 81,672,118.81 | 15,278,639.77 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,321,414.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,321,414.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,350,704.81 | 15,278,639.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,350,704.81 | 15,278,639.77 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,350,704.81)** | **(4,181,536.06)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 99,320.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 99,320.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (99,320.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,350,704.81)** | **(4,280,856.06)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,341,892,195.19 | 1,012,178,724.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 950,150.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 950,150.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 950,150.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 950,150.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,341,892,195.19 | 1,011,228,574.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 248,000,000.00 | 13,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,000,000.00 | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 240,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,093,892,195.19 | 998,228,574.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,093,892,195.19 | 998,228,574.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,343,242,900.00 | 997,853,724.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,343,242,900.00 | 997,853,724.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,261,570,781.19 | 967,296,444.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 474,707,925.19 | 520,183,420.23 |
| 210101 | Үндсэн цалин | 258,529,504.79 | 330,347,902.00 |
| 210102 | Нэмэгдэл | 185,113,013.93 | 142,809,911.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,728,644.61 | 18,210,072.00 |
| 210104 | Урамшуулал | 20,336,761.86 | 28,815,535.23 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 59,069,500.00 | 69,802,695.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40,167,200.00 | 48,975,889.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,725,600.00 | 5,289,616.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,362,800.00 | 2,721,881.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,362,800.00 | 2,576,082.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,451,100.00 | 10,239,227.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,138,298.00 | 35,626,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,015,550.00 | 4,243,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,339,460.00 | 25,572,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,783,288.00 | 5,811,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,020,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,020,000.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,521,020.00 | 13,218,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,521,020.00 | 595,100.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 12,623,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,927,350.00 | 15,781,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,927,350.00 | 15,781,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,359,740.00 | 5,007,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,767,340.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,471,500.00 | 1,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 99,300.00 | 127,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 21,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 3,680,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 655,826,948.00 | 307,676,229.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 595,650,248.00 | 300,176,529.23 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 60,176,700.00 | 7,499,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,672,118.81 | 30,557,279.54 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 80,321,414.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 80,321,414.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 15,278,639.77 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 15,278,639.77 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,350,704.81 | 15,278,639.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,350,704.81 | 15,278,639.77 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (1,350,704.81) | 14,325,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 5,870,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 5,870,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 5,870,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 5,870,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (5,870,000.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | (1,350,704.81) | 8,455,000.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 8,455,000.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний  бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 158,734,618.96 | - | - | 158,734,618.96 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 158,734,618.96 | 51,845,888.40 | (143,106,429.10) | 67,474,078.26 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 158,734,618.96 | - | - | 158,734,618.96 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (4,280,856.06) | (4,280,856.06) |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 158,734,618.96 | 51,845,888.40 | (147,387,285.16) | 63,193,222.20 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,681,881,500.00 | 975,445,084.23 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,681,881,500.00 | 975,445,084.23 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,681,881,500.00 | 975,445,084.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 674,998,600.00 | 530,183,420.23 |
| 210101 | Үндсэн цалин | 381,368,700.00 | 340,347,902.00 |
| 210102 | Нэмэгдэл | 218,864,200.00 | 142,809,911.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 18,210,072.00 |
| 210104 | Урамшуулал | 55,865,700.00 | 28,815,535.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 84,374,900.00 | 69,802,695.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,374,900.00 | 48,975,889.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,750,000.00 | 5,289,616.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,375,000.00 | 2,721,881.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,375,000.00 | 2,576,082.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,500,000.00 | 10,239,227.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,995,300.00 | 35,626,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,068,500.00 | 4,243,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 57,419,900.00 | 25,572,350.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,506,900.00 | 5,811,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 7,069,900.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,069,900.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,291,700.00 | 13,218,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,625,000.00 | 595,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,666,700.00 | 12,623,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 37,313,300.00 | 16,531,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,313,300.00 | 16,531,450.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,141,300.00 | 5,007,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13,500,000.00 | 1,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,500.00 | 108,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,800.00 | 19,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,500,000.00 | 3,680,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 765,696,500.00 | 305,074,719.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 714,863,300.00 | 297,575,019.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,833,200.00 | 7,499,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,681,881,500.00 | 983,900,084.23 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,681,881,500.00 | 982,949,934.23 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,681,881,500.00 | 982,949,934.23 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 950,150.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 950,150.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **8,455,000.00** |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **13,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **13,000,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 13,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 13,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 13,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 13,000,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 13,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 13,000,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нийт 41.4 төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. *Залруулсан алдаа:*

- Мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны орлогын дүнг 9.3 сая төгрөгөөр илүү, бараа үйлчилгээний бусад зардлын дүнг 2.7 сая төгрөгөөр дутуу, биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын 5.8 сая төгрөгийг тайлагнаагүй тул залруулав.
- Үр дүнгийн тайланд орон нутгаас авсан санхүүжилтийг 4.1 сая төгрөгөөр илүү, Бараа үйлчилгээний бусад зардлын дүнг 6.8 сая төгрөгөөр дутуу, цалингийн зардлын дүнг 10.0 сая төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлийг 25.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Цалин хөлс, орон тоотой холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн ИТХ нь ажлын албаны орон тоо 10 хүртэл, дээр нь Төрийн албаны тухай хуульд улс төрийн албан тушаалын 2 /ИТХ-ын дарга, даргын туслах бөгөөд өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн/ орон тоо байхаар заасан боловч аймгийн ИТХ-ын 2025.01.27-ны 3-р хуралдааны 37 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог 3-аар нэмж 16 орон тоогоор, аймгийн ИТХ-ын 2025.09.11-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор бүтэц орон тоог 16 /ажлын алба 10, туслах 5 орон тоо/ он тоогоор тус баталсан ба орон тоог 9%-иар бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоол, УИХ-ын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр баталсан "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Төрийн албаны реформын "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоол, УИХ-ын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдөр баталсан "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 48 дугаар тогтоолыг баримталж ажиллах.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш **30** хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг **2026 оны 10 дугаар сарын 10**-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 6,775.1 | | | 1 | 6,775.1 | 1 | 6,775.1 | | | | |
| Үр дүнгийн тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 9,329.8 | | | 1. | 9,329.8 | 1 | 9,329.8 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 25,278.6 | | | 1 | 25,278.6 | 1 | 25,278.6 | | | | |
| **Дүн** | **3** | **41,383.6** | | | **3** | **41,383.6** | **3** | **41,383.6** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Засгийн газраас орон тоог 9%-иар бууруулах талаар арга хэмжээ аваагүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **1** | | | | | | **1** | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |